

**ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД, ТҮҮНИЙ ХУДАЛДАН
АВАЛТ, ЗАРЦУУЛСАН ХҮҮ ТӨЛБӨРИЙН
ТАЛААР ХИЙХ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга	2
Аудитын нэр, код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	4
Эрсдэлийн үнэлгээ	5
Аудитын арга зүй	6
Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд	6
Аудитын хугацаа	7
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	7
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам	7
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц	7

Хэвсрэлт №1 Эрсдэлийн үнэлгээ

Хэвсрэлт №2 Асуудлын шинжилгээ

Хэвсрэлт №3 Аудитын арга зүй

Хэвсрэлт №4 Аудитын дэлгэрэнгүй хөтөлбөр

Хэвсрэлт №5 Аудитын үр өгөөжийн төлөвлөгөө

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР


Д.ХҮРЭЛБААТАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аудитын нэр: Засгийн газрын бонд, түүний худалдан авалт, зарцуулсан хүү төлбөрийн талаар хийх гүйцэтгэлийн аудит

Аудитын код: ГАГ-2018-08-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилт: Засгийн газрын бонд, түүний худалдан авалт, зарцуулсан хүү төлбөрийн талаар аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Засгийн газрын бондын арилжаа оновчтой зохион байгуулагдсан эсэх,
- Бондын хүү, төлбөр зохистой түвшинд байгаа эсэх

Хамрах хүрээ: Аудитад 2012-2017 онд Засгийн газраас гаргасан бондын зарцуулалт, түүний эргэн төлөлт, хүү төлбөрт зарцуулсан зардлыг түүврийн аргаар сонгон, бонд гаргах, арилжаалахтай холбоотойгоор Монголбанк, Сангийн яам, Монголын хөрөнгийн бирж, Арилжааны төлбөр тооцооны төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн зарим үйл ажиллагааг хамруулан шалгана.

Үндсэн мэдээлэл: Засгийн газрын бонд гаргах, арилжих харилцааг Засгийн газрын 1996 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан журмыг мөрдөж зохицуулж байсан бөгөөд уг журмыг Засгийн газрын 2014 оны 371 дүгээр тогтоолоор хүчингүй болгон, "Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжих журам"-аар зохицуулахаар баталжээ.

Сангийн яам 2013-2017 онд 15,061.9 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,403 дотоод бондыг Монголбанк, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалсан байна.

Засгийн газар олон улсын зах зээлд 2012-2017 онуудад 3-10 жилийн хугацаатай 6.74 хувийн жигнэсэн дундаж хүүтэй 3.6 тэрбум ам.долларын Засгийн газрын бондыг гаргажээ.

Хүснэгт 1 Сангийн намнаас 2013-2015 онд арилжаасан үзэм цаас
(тэрбум төгрөгөөр)

№	Арилжаасан огтоо	Үзэм цаасны тоо	Үзэм цаасны хэрлэсэн дүн	Дундаж хугацаа (хоноо)	Жигнэсэн дундаж хүү
1	2013 он	237	2,648.70	506.99	10.23%
2	2014 он	255	2,588.56	540.26	12.79%
3	2015 он	253	2,545.45	261.74	14.62%
4	2016 он	308	3,902.53	461.49	12.88%
5	2017 он	297	3,376.64	355.50	14.24%
	Нийт	2403	15,061.89	437.35	12.95%

СЯ нь Засгийн газрын бондын эргэн төлөлт, хүүгийн төлбөрийг улсын төсвийн урсгал зардалд жил бүр тусган УИХ-аар батлуулж ирсэн бөгөөд 2013-2017 оны хугацаанд бондын үндсэн төлбөрт 13,069.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 2,675.6 тэрбум төгрөгийг төлжээ.

Хүснэгт 2 Засгийн газрын бонд, хүүгийн төлбөрт 2013-2015 онд зарцуулагдсан зардал
(тэрбум төгрөгөөр)

№	Тайлант он	Гадаад бондын эргэн төлөлт		Дотоод бондын эргэн төлөлт		Нийт бондын эргэн төлөлт	
		Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	2013 он	-	98.98	1,794.23	108.10	1,794.23	207.09
2	2014 он	-	130.74	1,395.13	208.72	1,395.13	339.47
3	2015 он	-	149.68	2,079.38	373.70	2,079.38	523.38
4	2016 он	-	218.62	1,725.53	426.27	1,725.53	644.89
5	2017 он	950.82	398.33	5,124.58	562.50	6,075.40	960.83
		950.82	996.35	12,118.85	1,679.30	13,069.67	2,675.66

**Эрсдэлийн
үнэлгээ:**

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг "дунд" гэж үнэлэв. (Эрсдэлийн үнэлгээг хэвсралт №1-д үзүүлэв)

**Аудитын арга
зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, Засгийн газрын төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн гүйцэтгэлд тусгагдсан үндсэн үзүүлэлтэд тулгуурлан дүн шинжилгээ хийх, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. (Асуудлын шинжилгээг хэвсралт №2, арга зүйг хэвсралт №3-т үзүүлэв)

**Аудитад
ашиглах хууль
тогтоомж,
шалгуур
үзүүлэлтүүд:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Монгол Улсын 2012-2016 оны төсвийн тухай хуулиуд болон тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;

- Өрийн удирдлагын тухай хууль 2015 он;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл (2012-2016)
- Төв банк (Монголбанк)-ны тухай хууль;
- Үнэт цаасны тухай хууль;
- Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг (УИХ-ын 2015 оны 51 дүгээр тогтоол)
- Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжих журам (Засгийн газрын 2014 оны 371 дүгээр тогтоол)
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд;
- Улсын өрийн аудитын удирдамж АДБОУС 5400-5499

Аудитын хугацаа:

Аудитыг 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдөр эхэлж, талбарын ажлыг 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдөр дуусгах ба холбогдох үе шатны хяналтаар хянуулан, 2018 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн дотор Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталгаажуулан Улсын Их Хуралд хүргүүлнэ. *(Аудитын дэлгэрэнгүй хөтөлбөрийг хаералт №4-д үзүүлэв)*

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням удирдаж, аудитын менежер Л.Эрдэнэчулуун үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитын багийг талбар дээр ахлах аудитор Б.Хишигтогтох ахлан, аудитор Б.Анхбаатар, И.Туяадарь нар төлөвлөгөө, хөтөлбөр, батлагдсан хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх горим

Аудитын тайлан нь аудитын хураангуй, оршил хэсэг, аудитын дүн, дүлэвт, холбогдох газруудын сөнөл, аудитын зөвлөмж гэсэн агуулгаар үндсэн зорилтын хүрээнд бичигдэнэ.

Аудитын тайланг ҮАГ-ын Аудитын зөвлөлөөр хэлэлцүүлэн, дунг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлуулан Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хөтөлбөрт заасан хугацаанд хүргүүлсэн байна.

Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

Аудитад шаардагдах зардлын тооцоолол дараах байдалтай байна. Үүнд:

А. Хүний нөөц: ҮАГ-аас 3 хүн - 126 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц: Цалин – 6,070.0 мян/төгрөг
Бичиг хэрэг – 1,000.0 мян/төг

В.Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

АУДИТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨГ

Хянаж зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 С.ОЮУНБИЛЭГ

Боловсруулсан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

 М.ДАВААНЯМ

АУДИТЫН
МЕНЕЖЕР

 Л.ЭРДЭНЭЧУЛУУН

АХЛАХ АУДИТОР

 Б.ХИШИГТОГТОХ

АУДИТОР


 Б.АНХБААТАР
И.ТУЯАДАРЬ